

Батлав:

БОАЖЯ, ХБОБНУГ-ын дарга:

/ А. ЭНХБАТ/

Зөвшөөрч, хэрэгжүүлэх үүрэг хүлээсэн:

“Цээцээ импекс” ХХК-ийн захирал:*Лавин*...../Э.ГАНТУЯА/



**УЛААНБААТАР ХОТЫН ХАН-УУЛ ДҮҮРГИЙН НУТАГ ДЭВСГЭРТ
ОРШИХ “МОРИН-УУЛЫН ӨМНӨД ХЭСГИЙН БАРИЛГЫН
ЧУЛУУНЫ ОРД”-ЫН 2023 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ ТӨСЛИЙН
БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ**

/Тусгай зөвшөөрлийн дугаар 19/МО17

/Аж ахуй нэгжийн регистрийн дугаар 5282586/

Хянасан:

БОАЖЯ, ХБОБНУГ-ын

ахлах мэргэжилтэн:

/ Ц. ЖАРГАЛНЭМЭХ/

Төв аймгийн БОАЖГ-ын

ахлах мэргэжилтэн:

/ С.ЭРДЭНЭЦОГТ /

Боловсруулсан:

“ЦЭЭЦЭЭ ИМПЕКС” ХХК-ийн

Байгаль орчны мэргэжилтэн:

З. Болорцэцэг

/З. БОЛОРЦЭЦЭГ/

**УЛААНБААТАР ХОТ
2022 ОН**

ГАРЧИГ

Оршил	2
Нэг. Төслийн танилцуулга	3
Хоёр. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн товч танилцуулга	5
Гурав. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт	7
Дөрөв. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ	9
Тав. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12
5.1. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	12
5.2. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө.....	14
5.3. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	14
5.4. Нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох арга хэмжээний төлөвлөгөө.....	15
5.5. Түүх, соёлын өвийг хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	15
5.6. Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө	15
5.7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	17
5.8. Хог, хаягдлын менежментийн төлөвлөгөө	17
5.9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	19
5.10. Бомт-г хэрэгжүүлэх удирдлага, зохион байгуулалтын төлөвлөгөө	21
5.11. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	22
5.12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал.....	23
дүгнэлт	24
ашигласан хэвлэл	25

ХҮСНЭГТИЙН ЖАГСААЛТ

Хүснэгт №1. Үзүүлэлт /”Цээцээ Импекс” ХХК/	3
Хүснэгт №2. Уурхайн солбилцол	4
Хүснэгт №3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө.....	12
Хүснэгт №4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө	14
Хүснэгт №5. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө.....	14
Хүснэгт №6. Химийн бодисын эрсдлийн менежментийн төлөвлөгөө	16
Хүснэгт №7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө	17
Хүснэгт №8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	17
Хүснэгт №9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр.....	20
Хүснэгт №10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө	21
Хүснэгт №11. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө	22
Хүснэгт №12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал	23

ОРШИЛ

“Цээцээ импекс” ХХК-ийн барилгын чулууны ордын байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа байгаль орчин, ногоон хөгжлийн яамны сайдын 2019 оны 10 дүгээр сарын 29 –ны өдрийн А/618 тоот тушаалаар батлагдсан аргачлалыг баримталсан бөгөөд БОМТ –нд багтах нүүлгэн шилжүүлэх, нөхөн олговор олгох зэрэг арга хэмжээний төлөвлөгөө зэрэг ажлууд хийгдэхгүй болно.

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, нөхөн сэргээх, дүйцүүлэн хамгаалах, тухайн жилийн БОМТ-г хэрэгжүүлэх удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөр, БОМТ-ий хэрэгжилтийн талаар оршин суугчид, оролцогч талуудад тайлагнах хуваарь зэрэг ажлууд багтсан.

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 6.3 сая төгрөг зарцуулахаар төлөвлөж тухайн ажлуудын хэмжээ, гарах үр дүн, хариуцах эзэн, баримталж ажиллах арга зүй, стандарт, холбогдох хууль тогтоомжийг тусгаж, зардлын задаргааг тусгав.

НЭГ. ТӨСЛИЙН ТАНИЛЦУУЛГА

Төлөвлөгөөний нэр: Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордын 2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

Төсөл хэрэгжүүлэгч байгууллага: “Цээцээ импекс” ХХК

Төслийн зорилго: Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордын барилгын чулуу олборлож, бутлан ангилан, сайн чанарын дайрга зах зээлд нийлүүлж борлуулахад чиглэнэ.

Төсөл хэрэгжүүлэгчийн танилцуулга

Хүснэгт №1. Үзүүлэлт /“Цээцээ Импекс” ХХК/


№	Үзүүлэлтүүд	
1	Аж ахуйн нэгжийн нэр	
2	Улсын бүртгэлийн дугаар	
3	Уурхайн нэр	
4	Ордын байршил	Нийслэл/Хот/ Аймаг
5		Сум/Дүүрэг
6	Ашигт малтмалын төрөл	
7	Ашиглалтын тусгай зөвшөөрлийн дугаар	
8	Ашиглалт эхэлсэн огноо	
9	Аж ахуйн нэгжийн хаяг	Аймаг/Хот
10		Сум/Дүүрэг
11		Баг/Хороо
12		Гудамж/Байр
13	Гар утас	
14	Захирлын хаяг	Нэр
15		Гар утас
16		Электрон шуудан

Төслийн байршил: “Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд” нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутаг дэвсгэрт байрладаг.

- Засаг захиргаа: Улаанбаатар хот, Хан-Уул дүүрэг,
- Ордын нэр: "Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд"
- Ашигт малтмалын үндсэн төрөл: Барилгын чулуу
- Трапецийн номенклатур: L-48-10
- Талбайн нийт хэмжээ: 54.07 га

№	Газарзүйн солбицол			Уртраг		
	Өргөрөг					
1	106	43	41.03	47	48	40
2	106	43	39.7	47	48	50.87
3	106	43	49.59	47	48	58
4	106	44	11.02	47	48	58
5	106	44	11.3	47	48	40
6	106	42	50	47	48	40
7	106	43	36.25	47	48	40
8	106	43	32.78	47	48	49.15
9	106	43	30.35	47	48	51.35
10	106	43	22.44	47	48	52.19
11	106	43	15.21	47	48	50.57
12	106	43	13.7	47	48	42.09
13	106	43	11.15	47	48	42.56
14	106	43	5.89	47	48	47.97
15	106	43	2.95	47	48	48.52
16	106	43	0.95	47	48	42.73
17	106	42	59.27	47	48	42.06
18	106	42	50	47	48	42.06

Зураг №1. Тусгай зөвшөөрөлтэй талбайн байр зүйн зураг



Орд ашиглах тусгай зөвшөөрөл: Нийслэлийн засаг даргын тамгын газраас “Цээцээ импекс” ХХК-д 54.07 гектар талбай бүхий уурхайн эдэлбэрт ашигт малтмал ашиглах эрхийг олгож 19/М017 дугаар бүхий гэрчилгээг 2019 оны 02 сарын 12-ны өдөр олгосон байна.

Төслийн үйлдвэрлэлийн нөөц: Ордын үйлдвэрлэлийн нөөц нь нийт магадласан В+С зэргээр 500.0 мян.м³ буюу 1,300.0 мян.тн дайрга болж байна.

Ил уурхайн талбай: Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордын уурхайн ашиглалтаар 2 ухаш үүснэ. Талбай-1 дэх ил уурхай ойролцоогоор 800 м урттай, 350 м өргөнтэй байх бөгөөд 18.3 га талбайг хамарсан ухаш үүсэх бол талбай-2 дахь ил уурхай ойролцоогоор 640 м урттай, 390 м өргөнтэй байх бөгөөд 23.8 га талбайг хамарсан ухаш болох юм.

Төслийн хүчин чадал: “Морин уулын өмнөд хэсгийн” барилгын чулууны уурхайгаас 2023 онд 474,7 мян.м³ барилгын чулуу олборлон борлуулна. Уурхай нь 4 сарын 15-аас 10 сарын 15-ны хооронд тасралтгүй ажиллана. Хоногт 2 ээлжээр, ээлжийн үргэлжлэх хугацаа 12 цаг байна.

Тэсэлгээний ажил: Тэсэлгээний ажилд дотоодод үйлдвэрлэж буй энгийн найрлагат “ANFO”, “Аянга” зэрэг энгийн найрлагат тэсрэх бодис, мөн эмульсийн тэсрэх бодисыг нонель системийн тэсэлгээний иж бүрдэл хэрэгсэлтэй хослуулан хэрэглэнэ. Тэсэлгээний ажлыг жилд 3 удаа хийх бөгөөд тэсэлгээний аюулгүй ажиллагааны зай 300 метр байна.

ХОЁР. ТӨСӨЛ ХЭРЭГЖИЖ БУЙ НУТГИЙН БАЙГАЛЬ ОРЧИН, НИЙГЭМ- ЭДИЙН ЗАСГИЙН ТОВЧ ТАНИЛЦУУЛГА

Байгаль орчны төлөв байдал

Ландшафт: “Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд” нь Газарзүйн мужлалаар ордын дүүрэг нь Төв Монголын хагарлын дагуух нутаг дэвсгэрийн Хэнтийн уулархаг мужийн баруун өмнөд хэсэгт харьяалагдана. Энэ дүүргийн дунд зэргийн өндөрлөгтэй бэсрэг уулс нь идэгдэлд орсон эгц хажуу шовх оройтой, хадан гарш, гуу жалга ихтэй.

Газарзүйн байрлал, газрын гадарга: Талбайн хойд, баруун хойт хэсгээр жижиг толгодлог болон хөндий бүхий нам уулсын гадаргуу зонхилох бөгөөд тэдгээр нь ерөнхийдөө баруун, баруун хойш чиглэлд сунаж тогтсон байдаг.

Уур амьсгал, агаарын чанар: Бүх талаараа Азийн өндөр уулсаар хүрээлэгдэж далай тэнгисээс ихээхэн алслагдсан, гипсометрийн өндөр байрлалд оршдог тул тэнгисийн чийглэг салхи нэвтрэх боломж тун бага байдаг онцлогтой. Цаг уурын энэ онцлог нь дүүргийг эх газрын эрс тэс уур амьсгалтай, улирлын болон хоногийн халуун хүйтний хэлбэлзэл, өөрчлөлт ихтэй болгодог.

Хамгийн хүйтэн үе нь 1-р сард -38°C, дулаан нь 7-р сард +33°C хүрнэ. Жилд унах хур тундасны дундаж хэмжээ 230-350 мм-с хүрдэг, түүний 60-70% нь зуны улиралд бороо хэлбэрээр унах ба 30-40% нь өвөл, хаврын улиралд цас хэлбэрээр унадаг. Харьцангуй чийглэг уур амьсгалтай ба харьцангуй дундаж чийгшилт 35% байна. Салхины хурд өвөлдөө 5-9 м/сек хүртэл салхилдаг. Цасан бүрхүүлийн зузаан 10-30 см орчим байдаг.

Усан орчин: Усан сүлжээ харьцангуй сайн хөгжсөн бүс нутагт багтана. Ордын дүүргээр Туул, Бүхэг, Түргэн зэрэг байнгын урсгалтай голууд урсан өнгөрдөг бөгөөд эдгээр голуудын гольдролын өргөн нь 30-70 м, гүн нь 0.5-1.5 м, урсгалын хурд дунджаар 1.0-1.6 м/сек гэж өмнөх судлаачид тогтоосон байна.

Ордын дүүргийн талбайд байгаа томоохон амууд, гуу жалга нь баруун, баруун хойш чиглэлтэй юм. Тэдгээрийн ихэнх нь эхэндээ бага зэргийн ундаргатай, булгуудтай, зарим нь түр зуурын урсгалтай жижиг горхиуд байдаг. Цас борооны усаар тэжээгддэг эдгээр горхиуд нь адаг руугаа шургаж тасардаг ба зарим нэг нь Бүхэг, Түргэний голд цутгадаг.

Судалгааны талбайн ойр орчимд олон тооны булаг шанд, гүний өрөмдмөл худаг байдаг бөгөөд энэ нь унд ахуйн хэрэглээний усны хэрэгцээг хангадаг. Тусгай зөвшөөрөлтэй “Сондуулт” талбайд ямар нэгэн булаг шанд, өрөмдмөл худаг байдаггүй бөгөөд хийсэн хайгуулын ажлын явцад уст давхарга илрээгүй.

Хөрсөн бүрхэвч: Төсөл хэрэгжих талбай нь ухаа толгод бүхий нутаг хамрагдах бөгөөд талбайд тархсан хөрсний хувьд зонхилох хэв шинж нь хар хүрэн хөрс, толгод болон нам уулсын хажуугаар чулуурхаг, нимгэн хар хүрэн, уулс хоорондын хөндийгөөр хар хүрэн тогтворжино.

Ургамлан нөмрөг: Ойт хээрийн ба хээрийн бүсийн өвслөг, цэцэгт ургамал, газар зүйн бүх төрлийг хамаарах бөгөөд хадлан, бэлчээр газар тариалангийн талбайн хувьд дунд зэрэг төлөвтэй.

Амьтан: Уулархаг хэсгээрээ шинэс, хуш, нарс зэрэг модод ургахаас гадна ой модтой уулархаг газартаа баавгай, чоно, булга, бор гөрөөс, талархаг газартаа тарвага, хярс, үнэг, зурам, огтоно, жигүүртнээс шаазгай, шар шувуу, хэрээ зэрэг ан амьтантай ба олон төрлийн шавьж байсан. Туул голдоо зэвэг, хадран, тул зэрэг агнуурын загастай байсан.

Түүх соёлын дурсгалд газрууд: Үйл ажиллагаа явуулах төслийн талбайд түүх соёлын дурсгалт газрууд илрээгүй.

Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нийгэм эдийн засгийн үзүүлэлт: Улаанбаатар хотод монгол улсын бараг тэн хагас хүн ам буюу 1.440.400 хүн (2021 оны байдлаар) амьдран суудаг бөгөөд үүнээс Хан-Уул дүүрэг нь 16 хороотой бөгөөд нийт 45200 өрх буюу 159470 хүн амьдран суудаг. Эдийн засгийн хувьд төвийн бүсэд багтдаг бөгөөд аж үйлдвэрийн салбар, дэд бүтэц сайн хөгжсөн бүс нутагт харьяалагдана.

Хан-Уул дүүрэг нь 11633 гаруй аж ахуйн нэгж, үйлдвэр, компани, нөхөрлөл, хоршоотой бөгөөд 38.8 мянга гаруй толгой малтай, 321.3 мянга гаруй тахиа, 50.7 мянга гаруй гахай бүхий эрчимжсэн аж ахуйтай, хүлэмжийн аж ахуй, агро парк бүхий газар тариалан хөгжсөн бүс нутаг юм.

Хан-Уул дүүрэг нь 48500 га нутаг дэвсгэртэй, үүнээс 21.1 хувь буюу 10226 га нь ой мод, гол горхи, рашаан ус бүхий дархлагдсан ногоон бүс, 67.6 хувь 32763 га нь хөдөө аж ахуйн эдэлбэр газар, 11.3 хувь буюу 5499 га нь хот суурин, зам харилцааны сүлжээ, нийтийн эзэмшлийн газарт хамаардаг.

Жилийн аль ч улиралд авто замын тээврээр уг талбайн аль ч хэсэгт зорчин очих боломжтой. Сүүлийн жилүүдэд геологийн судалгаагаар үйлдвэрлэлийн ач холбогдолтой барилгын материалын түүхий эдийн олон ордууд нээгдэж, түүнийг түшиглэн барилгын материалын үйлдвэр, автозамын болон барилгын хайрга, дайрга олборлох карьерийн аж ахуйнууд үйл ажиллагаагаа эрхлэн асфальт, бетон зуурмаг үйлдвэрлэж байна.

ГУРАВ. ТӨСЛИЙН ГОЛ БА БОЛЗОШГҮЙ СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙН ТОВЧ ТОДОРХОЙЛОЛТ

Төслийн талбай нь Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт байрлах “Цээцээ импекс” ХХК нь 19/М017 тоот тусгай зөвшөөрөл бүхий 54.07 га талбай “Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд”-ыг ил аргаар ашиглах төсөл хэрэгжүүлнэ.

Газрын гадарга, хэвлийд үзүүлэх сөрөг нөлөөлөл: Уурхайд төсөл хэрэгжих 30 жилийн турш элс тээвэрлэлт явагдах тул талбайн ойр орчмын газрын гадаргыг тоос дарж хөрс, ургамал, орчныг бохирдуулна. Мөн өрөмдлөг тэсэлгээний үед ялгарах их хэмжээний тоос орчныг бохирдуулна.

Шимт хөрсийг 0.15-0.2 м зузаантайгаар хуулж хүний хөлөөс зайдуу салхины нөмөр газар 8-10 метрийн өндөртэй байгуулна. Шимт хөрсний овоолго үүсгэсний дараа хөрс нь сийрэгжсэн байх учир салхинд хийсэх, бороо болон үерийн усанд урсах зэрэг сөрөг нөлөөтэй.

Овоолго үүсэх үед элс буулгах, ачих тээвэрлэх, уруу газар ачих зэрэгт байнгын тоосжилт үүсэх ба энэ нь гадаргад бохирдол үүсгэж болзошгүй. Байршлын хувьд ил уурхайтай ойрхон төлөвлөсөн нь машин техникээс үүсэх бохирдол бага байх эерэг нөлөөтэй. Түр овоолго үүсгээд буцаан ашиглаж, үйл ажиллагаа дууссаны дараа тэр хэсгийг бүрэн нөхөн сэргээгдэх боломжтой.

Хогийн цэгээс үүсч болзошгүй сөрөг нөлөөлөл: Хогийн цэг байгуулах талбайд төслийн хугацааны явцад засвар үйлчилгээний төв болон ажилчдын тосгоноос гарсан хог хаягдал үүссэнээр газрын гадаргад бохирдол үүснэ. Хэдийгээр дунд хугацаанд нөлөөлөл үзүүлэх боловч төслийн хугацаа дуусахад эргэн нөхөн сэргээгдэх боломжтой.

Агаарын чанарт үзүүлэх сөрөг нөлөөлөл: Замын хөдөлгөөн, тэсэлгээ хөрс хуулалт, тээвэрлэлтээс үүдэлтэй агаарын тоосжилт, дизель түлшээр ажилладаг машин механизм тоног төхөөрөмж, тэсэлгээнээс үүссэн бохир хий утаа, дуу чимээ, хог хаягдлаас үүсэх үнэр зэрэг болно.

Усан орчинд үзүүлэх сөрөг нөлөөлөл: Шугам хоолойг газарт байрлуулах барилга угсралтын үед хур тунадас болон үерийн усаар угаагдсан барилгын материалд агуулагдах бодисууд угаагдан урсаж, хөрсөнд нэвчиж хөрсний бага гүний усыг бохирдуулж болзошгүй.

Өрөмдлөг тэсэлгээний үед тэсэлгээний бодисын нөлөөгөөр хөрсний ус бохирдон, улмаар нэвчилт үүсэн газрын доорх усны чанар өөрчлөгдөж болзошгүй. Шатахуун түгээх станц,

агуулахын орчноос үерийн усны нөлөөгөөр дамжин хяналтгүй урсац алдагдаж, улмаар хөрсний усны чанарт нөлөөлөх,

Уул уурхайн ашиглалтын болон боловсруулах үйл ажиллагаанд түлш, тос тосолгооны материал, тэсрэх бодис зэрэг аюултай бодисуудыг ашиглахаар байна. Хөрсний гүний усны үеүдэд шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн, тэсрэх бодис, бохир усны алдагдал, нэвчилтээс бохирдох эрсдэл үүсч болзошгүй учраас уурхайн зүгээс аюулгүй ажиллагааны дүрмийг сайтар баримтлан ажиллах нь зүйтэй.

Хөрсөн бүрхэвчид үзүүлэх сөрөг нөлөөлөх: Олборлолтын явцад хөрс их хэмжээгээр эвдрэх, үүний улмаас хөрсний морфологи болон физик шинж чанар алдагдаж хөрсний үржил шим буурах, ойр орчмын талбайн хөрс доройтолд өртөнө. Их хэмжээний үржил шимт хөрс болон “Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд”-оос эрүүл талбай хөрсний овоолгод дарагдах, хөрсний гадарга дээр нарийн ширхэгт тоосны хучаас үе үүснэ. Газрын хэвлийд хоосон хөндий орон зай үүснэ. Машин техникийн олон салаа зам үүсч талбайн ургамлыг сүйтгэж, хөрсийг халцалж, газрыг элэгдэл эвдрэлд оруулан, тоос шороо ихээр дэгдэж агаар, орчны хөрс ургамлыг бохирдуулна. Хүн амын суурьшил нягтарснаас хөрсний элэгдэл эвдрэл, бохирдол үүснэ. Хүнд даацын машин механизм, түүний тээвэрлэлт, засвар үйлчилгээний улмаас шатах, тослох материал, нефтийн бүтээгдэхүүн хөрсөнд нэвчиж хөрс бохирдуулна.

Ургамлан нөмрөгт үзүүлэх нөлөөлөл: Ил уурхайн талбайд байсан ургамал устана. Уурхайд олон янзын зориулалтаар машин техник ашиглаж, тэдгээрээс үүдэн олон салаа зам үүсч бий болох магадлалтай. Олон салаа зам үүссэнтэй холбоотойгоор газрын гадаргад шороо тоос үүсч, улмаар салхи шуурганд хийсэн ойр орчмын ургамал бүрхэвч, төслийн талбай тоос шороонд дарагдаж болзошгүй. Байгууламжууд баригдах талбай нь төслийн хугацаанд хүний хөлөөр болон тээврийн хэрэгслээр талхлагдаж бүрэн өөрчлөлтөнд орно. Тосгоноос ахуйн хог хаягдал их хэмжээгээр үүсч, хадгалах зайлуулах стандарт, дүрэм, журам барьж ажиллаагүйгээс гадаргад бохирдол үүсч болзошгүй. Хогийн цэг байгуулах талбайд төслийн хугацааны явцад засвар үйлчилгээний төв болон ажилчдын тосгоноос гарсан хог хаягдал үүссэнээр газрын гадарга болон ургамлан нөмрөгт бохирдол үүснэ. Тоосжилт үүссэнээс ойр орчмын ургамлууд дээр бууж, үүнээс шалтгаалан навч гэрлийг шингээх нь буурч ургамлын фотосинтезийн бүтээмж доройтох болно.

Амьтны аймагт үзүүлэх сөрөг нөлөөлөл: Олборлолт хийх, хөрс хуулах, овоолго хийх, барилга байгууламж барих, техник хэрэгсэл явах зам тавих, кемп барьсны улмаас эдгээр үйл ажиллагаанд өртсөн талбайн амьтны аймаг, ялангуяа мэрэгчид, шавж, мөлхөгчид устаж үгүй болж тэдгээрийн амьдрах орчин байхгүй болно. Олборлолт явуулсны улмаас хөрс хуулж овоолго хийгээд орхисон байгаа ба овоолго болон түүний орчмын талбайн амьтан, тэдгээрийн амьдрах орчин үгүй болжээ. Цаашид талбайг тэлэх тутам амьтны аймагт учрах хохирол нэмэгдэх болно. Үүссэн овоолгод техникийн болон биологийн нөхөн сэргээлт тухай бүр хийхгүйгээс тус нутгийн амьтны аймаг нөхөн сэргэх хугацаа сунжирна.

Тээврийн хэрэгсэл, тэсэлгээний үеийн дуу чимээнээс хүн амьтан үргэж, дайжих, байршил тархалт нь өөрчлөгдөх, ая тухгүй болно. Хөрс хуулалт, овоолго хийх, зам, барилга байгууламж барихад тухайн газрын амьтны аймаг устана. Шавжны аймгийн тархалт

байршилд өөрчлөлт гарна. Хог хаягдал, ариун цэвэр бохирын асуудлыг сайтар төлөвлөхгүй бол хүнд ойромсог амьдардаг, хог хаягдлын индикатор амьтдын зүйлийн тоо толгой ихсэх магадлалтай.

Түүх соёлын дурсгалт зүйлст үзүүлэх сөрөг нөлөөлөл: “Цээцээ импекс” ХХК-ийн ашиглалтын 54.07 га талбайд ямар нэгэн түүх соёлын дурсгал илрээгүй байна. Ашиглалт явуулах 54.07 га талбайд ямар нэгэн түүх, соёлын ямар нэгэн дурсгалт зүйл илрээгүй боловч олборлолтын үед газар дээр ямар нэгэн түүх соёлын дурсгалт зүйлс илэрсэн тохиолдолд төсөл хэрэгжүүлэгч нь ажлаа зогсоож, энэ тухай дүүрэг, дүүргийн Засаг дарга, цагдаагийн болон уг асуудлыг эрхэлсэн эрдэм шинжилгээний байгууллагуудад нэн даруй мэдэгдэх шаардлагатай.

Нийгэм эдийн засагт үзүүлэх нөлөөлөл: Төслийн хугацаанд уурхайн нарийн мэргэжил шаардагдахгүй ажилд орон нутгийн иргэдээс ажиллуулах ба цөөн хэдэн хүнийг ажлын байраар хангах бөгөөд олборлолтын хугацаанд нутгийн иргэдээс өргөн хэрэглээний бараа, хүнсний тодорхой бүтээгдэхүүн (мах, цагаан идээ, гурил, будаа мөн ариун цэврийн бүтээгдэхүүнүүд г.м) худалдан авах зэргээр бага хэмжээний орлогыг нутгийн иргэдэд оруулах юм.

Ажилчдын байрны эрүүл ахуй, хөдөлмөрийн нөхцлийг шаардлагын хэмжээнд байлгаж чадсанаар ажиллагсдын мэргэжлээс шалтгаалах өвчлөл, хөдөлмөрийн чадвараа түр алдалт, үйлдвэрлэлийн ослоос урьдчилан сэргийлж чадна. Уурхайн ажлын үед ажиллах хүнд машин механизмын дуу чимээ, тоосжилт ихэссэнээс хүн амын эрүүл мэндэд сөрөг нөлөөлөл үзүүлж болзошгүй.

Болзошгүй осол аваар, саатал, техник, технологийн шугам сүлжээний гэмтэл, гал усны гэнэтийн аюул учирч болзошгүй. Үйл ажиллагааны явцдаа техникийн аюулгүй байдал алдагдах, гэнэтийн осол гарснаас ажилчдын эрүүл мэнд, амь нас эрсдэх аюул үүснэ.

ДӨРӨВ. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ГОЛ ЗОРИЛТ, ХАМРАХ ХҮРЭЭ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хамрах хүрээ, гол зорилт: Энэхүү тайлангийн байгаль орчны менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, орчны хяналт шинжилгээний хөтөлбөрөөс бүрдэнэ. Байгаль орчны хэрэгжиж бүхий нутаг дэвсгэрийн байгаль орчныг хамгаалахтай холбогдсон арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд оршино.

Энэхүү төлөвлөгөө нь төслийн үйл ажиллагаа эхлээгүй үед хийгдэж байгаа учраас байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайланд үндэслэгдсэн дараа дараачийн жилүүдэд хянан үзэж, шинэчлэн сайжруулж байх шаардлагатай бөгөөд байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрүүдээс гарч буй үр дүнтэй уялдуулах нь зүйтэй. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд тусгаснаар төслийн үйл ажиллагаа болон түүний хүрээлэн буй нутаг дэвсгэр дэх бүх сөрөг өөрчлөлтүүдэд үнэлгээ хийх хэрэгтэй. Мөн түүнчлэн байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийн ажлын үр дүнгүүдэд үнэлгээ хийх шаардлагатай. Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөнд байгаль орчны нөлөөллийн

үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, нөхөн сэргээлт хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгасан.

БОМТ боловсруулах, хэрэгжүүлэх үндэслэл: Олон улсад түгээмэл хэрэглэгддэг тодорхойлолтоор Байгаль орчны менежмент гэдэг нь аливаа байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх ба хэрэгжилтийн явц, үр дүнг хянах удирдлагын үйл ажиллагаа бөгөөд энэ нь Байгаль орчны менежментийн төлөвлөгөө (БОМТ) –ний дагуу Байгаль орчны удирдлагын тогтолцоо (БОУТ) –гоор хэрэгжих учиртай. БОМТ гэдэг нь тодорхой газар нутгийн байгаль орчныг хамгаалж холбогдох хууль журмыг сахих зорилгоор хийгдэх ажил, арга хэмжээний төлөвлөгөө юм. MNS (ISO) 2006 стандартад зааснаар БОУТ гэдэг нь байгууллагын удирдлагын тогтолцооны нэг хэсэг бөгөөд тухайн байгууллагын байгаль орчны бодлогыг боловсруулах, хэрэгжүүлэх болон байгаль орчинтой холбоотой асуудлыг хариуцах үүрэгтэй.

2012 онд нэмэлт өөрчлөлт орсон Байгаль орчныг хамгаалах тухай Монгол Улсын хуулийн 31-р зүйлд зааснаар аливаа бохирдлын эх үүсвэр бүхий аж ахуйн нэгж, байгууллага нь БОМТ-ний хэрэгжилтийг хангах, өөрийн үйл ажиллагаанаас байгаль орчинд ялгаруулах хатуу, шингэн, хийн хаягдлыг хянах ажлыг зохион байгуулж ажиллуулах дотоод хяналтын нэгжтэй байх (заалт 31.7), байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлыг төсөвтөө тусган хэрэгжүүлэх (заалт 31.4), БОМТ-г хэрэгжүүлэхэд шаардагдах зардлын 50%-тай тэнцэх хэмжээний мөнгөн хөрөнгийг нөхөн сэргээлтийн тусгай дансанд төвлөрүүлэх (заалт 31.10, 31.11) зэрэг үүрэгтэй (МУ хууль, БОХ тухай, 2012).

БОМТ-ний бүрдэл хэсэг, агуулга: Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулийн (МУ хууль, БОНБУ-ний тухай, 2012) 9 дүгээр зүйлд зааснаар БОМТ нь Байгаль хамгаалах төлөвлөгөө (БХТ), орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр (ОХШХ)-өөс бүрдэнэ (заалт 9.5). БХТ-нд байгаль орчны нөлөөллийн үнэлгээгээр тогтоосон сөрөг нөлөөллийг багасгах, арилгах арга хэмжээ, дүйцүүлэн хамгаалал хийх, тэдгээрийг хэрэгжүүлэх хугацаа, шаардагдах хөрөнгө зардлыг тусгана (заалт 9.6). ОХШХ-т төслийн үйл ажиллагааны улмаас байгаль орчны төлөв байдалд үзүүлж байгаа өөрчлөлтийг хянах, шинжилгээ хийх, үр дүнг тайлагнах, түүнийг хэрэгжүүлэх арга хэлбэр, шаардагдах хөрөнгө зардал, хугацааг тодорхойлон тусгана (заалт 9.7).

Хуульд БОМТ-ний хэрэгжилтэнд байгаль хамгаалагч, БО-ны улсын байцаагч, Засаг дарга, төрийн захиргааны төв байгууллага, БО-ны ТББ хяналт тавина гэж заасан байна. Үүн дээр тухайн газар нутагт гарч байгаа өөрчлөлтийг хамгийн сайн мэдэх нутгийн малчид, ард иргэд болон шинжлэх ухааны үндэслэлтэй үнэлгээ, дүгнэлт өгөх мэргэжлийн байгууллагын хяналт зайлшгүй байх ёстой гэж үзэн нэмж оруулсан.

Өнөөгийн байдлаар БОМТ-г боловсруулах, хэрэгжүүлэхэд гарын авлага болох нарийвчилсан заавар, журам, аргачлал гараагүй байгаа ба 2013 онд БОАЖЯ-наас боловсруулсан Байгаль орчны нөлөөллийн үнэлгээний журмын төсөлд БОМТ-д дараах зүйлийг оруулахаар тусгасан байна (БОНХЯ, 2013):

Байгаль хамгаалах төлөвлөгөө:

- ✓ Төслийн гол болон болзошгүй нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах арга хэмжээ
- ✓ Уул уурхайн төслийн хаалтын үед авч хэрэгжүүлэх гол арга хэмжээ, хамрах хүрээ;
- ✓ БОМТ-г хэрэгжүүлэх хүний нөөц, БО-ны удирдлагын бүтэц зохион байгуулалт;
- ✓ БОМТ-ний хэрэгжилтийн явц, үр дүнг холбогдох төрийн байгууллага, олон нийтэд тайлагнах төлөвлөгөө;

Орчны хяналт-шинжилгээний хөтөлбөр:

- ✓ Нөлөөлөлд өртөж болзошгүй байгаль орчин, хүний эрүүл мэнд, нийгмийн төлөв байдлын суурь мэдээлэл ба төсөл хэрэгжсэнээр түүнд гарч болзошгүй тоон ба чанарын өөрчлөлт;
- ✓ Нөлөөллийг багасгах, арилгах, нөхөн сэргээх, хоргүйжүүлэх, саармагжуулах арга хэмжээний үр дүнг хэмжих тоон ба чанарын үзүүлэлтүүд;
- ✓ Төсөл хэрэгжүүлэгчийн мөрдөн ажиллах Монгол улсын нэгдэн орсон олон улсын гэрээ, Монгол улсын хууль тогтоомж, стандарт болон хэм хэмжээний үзүүлэлтүүд;
- ✓ Хяналт-шинжилгээ хийх шаардлагатай байгаль орчны бүрэлдэхүүн хэсгүүд, сөрөг нөлөөллийг бууруулах, арилгах, нөхөн сэргээх арга хэмжээнүүд, нөлөөллийг хэмжих хэмжигдэхүүн;
- ✓ Сорьц авах, хэмжилт хийх, түүнд дүн шинжилгээ хийх арга, байршил, хугацаа, давтамж;

БОМТ-ний бүтэц: БОМТ-ний бүрэлдэхүүнд 3 бүлэг, 6 ерөнхий хэсэгтэй.

1. Оршил
2. Төслийн товч танилцуулга
3. Төсөл хэрэгжиж буй нутгийн байгаль орчин, нийгэм-эдийн засгийн товч танилцуулга
4. Төслийн гол ба болзошгүй сөрөг нөлөөллийн товч тодорхойлолт
5. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний гол зорилт, хамрах хүрээ
6. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө
7. Дүгнэлт

ТАВ. СӨРӨГ НӨЛӨӨЛЛИЙГ БУУРУУЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

5.1. Сөрөг нөлөөллөөс урьдчилан сэргийлэх, бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

Хүснэгт №3. Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө

№	Гол болон болзошгүй сөрөг нөлөөллүүд	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн үнэлгээ	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах эрх зүйн баримт бичиг
Агаарын чанар								
1	Хөрс хуулалт, барилгын чулуу олборлолт, тээвэрлэлт, элс, хөрсний овоолгоноос тоосжилт үүсэж орчны агаар орчныг бохирдуулах	Тоос үүсгэх талбайг тогтмол услах	Уурхайн зам	-	-	Усны төлбөрт орсон	Тогтмол	-Агаарын ба агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль, -MNS 0017-2-3-16:1998 (хүн ам суурьшсан хэсгүүдэд) Бензин хөдөлгүүрт MNS 5013:2003 Дизель хөдөлгүүрт MNS 5014:2003 -Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль,
2	Хүнд машин механизмын нөлөөгөөр Нох, СО, Sox хийгээр агаар орчныг бохирдуулах	Жилд нэг удаа хүнд машин механизмуудыг техникийн үзлэгт оруулах, засвар үйлчилгээг тогтмол хийх	Хүнд машин, техникүүд	-	-	200,000	2023 онд	-Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль,
Гадаргын ба газрын доорх усны нөөц								
3	Гүний усны нөөцөд нөлөөлөх эсэх. Хөрсний усыг бохирдуулахгүй байх	Усны хэмнэлттэй ашиглах, усыг дахин ашиглах	-	Дотоод төлөвлөлтөөр зохицуулах	-	-	Үйл ажиллагааны туршид	-Ус ашигласны төлбөр (2013 оны 327-р тогтоол) -Усны тухай хууль, -“Газар доорх усыг бохирдлоос хамгаалах” MNS 3342:1982
Газрын хэвлий, хөрсөн бүрхэвч								

4	Хүнд даацын машин механизмууд олон салаа зам гаргаж хөрс болон ургамлыг гэмтээх	Тээврийн хэрэгсэлийг маршрутын бус замаар явуулахыг хориглосон таних тэмдэг бүхий самбаруудыг байрлуулах, сайжруулах.	-	-	-	300,000	Жил болгон /эвдэрсэн тохиолдолд засварлана/
5	Машин техникийн засвар үйлчилгээ бусад үйл ажиллагаанаас хөрс бохирдуулах	Засвар үйлчилгээ хийхэд хөрсийг нефтийн бүтээгдэхүүнээр бохирдуулахгүй байх нөхцөл бүрдүүлэх бохирдсон хөрсийг тухай бүр хуулж цэвэрлэж шинэ хөрсөөр сэлбэх	-	-	-	-	Жил бүр
7	Хөрсний бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдөх	Уулын ажлыг зөвхөн уулын ажлын төлөвлөгөөний дагуу хийж гүйцэтгэх	Уурхайн талбайд	-	-	-	
Ургамлан нөмрөг							
9	Ургамлын биомассд нөлөөлөх эсэх	Тоос үүсэх талбайг услах	Уурхайн зам	Усалгааны зардалд орсон	-	-	Байнга
Нийт зардал					500,000		

5.2. НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №4. Нөхөн сэргээлтийн төлөвлөгөө

№	Нөхөн сэргээлтийн зорилт	Нөхөн сэргээлтийн арга хэмжээ	Хэмжих нэгж	Нэг-жийн зардал, төг	Нийт зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Техникийн нөхөн сэргээлт	ТНС хийгдэхгүй	-	-	-	-	MNS5914:2008 Эвдэрсэн газрын нөхөн сэргээлтийн нэр томъёо, тодорхойлолт MNS 5915:2008 Уул уурхайн үйл ажиллагаагаар эвдэрсэн газрын ангилал
2	Биологийн нөхөн сэргээлт	БНС хийгдэхгүй	-	-	-	-	MNS 5916:2008 Газар шорооны ажлын үеийн үржил шимт хөрс хуулалт, хадгалалт MNS 5917:2008 Уул уурхайн үйл ажиллагаар эвдэрсэн газрын нөхөн сэргээлт MNS 5918:2008 Эвдэрсэн газрыг ургамалжуулах.Техникийн шаардлага MNS 4919:2000 Эвдэрсэн газарт хучилт хийх хөрс. Техникийн шаардлага MNS 4920:2000 Эвдэрсэн газрын хажуугийн налуу. Техникийн шаардлага
Нийт							-

5.3. БИОЛОГИЙН ОЛОН ЯНЗ БАЙДЛЫГ ДҮЙЦҮҮЛЭН ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Хүснэгт №5. Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө

№	Дүйцүүлэн хамгаалах зорилт	Хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төг	Хэрэгжүүлэх хугацаа, давтамж	Баримтлах стандарт, аргачлал
1	Биологийн олон янз байдлыг дүйцүүлэн хамгаалах арга хэмжээ	Нийслэлийн байгаль орчны газар болон тус дүүргийн иргэдтэй зөвлөлдөн дэмжлэг үзүүлж хамтран ажиллах	-	-	5,900.000	2023 онд	МУ-ын хууль дүрэм журмын дагуу
Нийт						5,900,000.0	

5.4. НҮҮЛГЭН ШИЛЖҮҮЛЭХ, НӨХӨН ОЛГОВОР ОЛГОХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

“Морин-Уул” Барилгын чулууны дордын талбайд болон түүний ойр орчмын нөлөөллийн бүсэд айл өрх байхгүй учир нүүлгэн шилжүүлэх арга хэмжээ шаардлагагүй.

5.5. ТҮҮХ, СОЁЛЫН ӨВИЙГ ХАМГААЛАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ

Барилгын чулууны ордын эзэмшлийн талбайд түүх, соёлын дурсгалт зүйлс илрээгүй байна. Хэрэв уурхайн эдэлбэр газарт түүх соёлын дурсгалын зүйлс, археологи, палентлогийн олдвор илэрсэн тохиолдолд дүүрэг, хорооны захиргаанд болон мэргэжлийн байгууллагуудад мэдэгдэж зохих судалгаа, шинжилгээ хийлгэн дүгнэлт гаргуулах шаардлагатай.

5.6. ХИМИЙН БОДИСЫН ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Цээцээ Импекс” ХХК-ийн “Морин-Уул” барилгын чулууны орд нь тэсэлгээний ажилд дотооддоо үйлдвэрлэж буй энгийн найрлагат “ANFO” “Аянга” зэрэг эмульсийн тэсрэх бодисыг нонель системийн тэсэлгээний иж бүрдэл хэрэгсэлтэй хослуулан ашигладаг. Тэсрэх материал тэсэлгээний хэрэгслийг хотын ойролцоо орших агуулахаас зөөж тээвэрлэн мэргэжлийн байгууллагаар хийлгэдэг. Тэсэлгээний ажлыг тусгай зөвшөөрөл бүхий тэсэлгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг "Пауэр бласт" ХХК-р хийлгэхээр төлөвлөж байгаа бөгөөд 1 удаагийн тэсэлгээнд шаардагдах тэсрэх бодис, материалыг холбогдох байгууллагууд түүний агуулах үйлдвэрээс худалдан, тээвэрлэн авч ирж тэсэлгээг хийнэ.

Хүснэгт №6. Химийн бодисын эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөө	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Хариуцах эзэн	Нийт зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт аргачлал
1	Тэсрэх бодис тэсрэх, асгарах, хэрэглэсэн тэсрэх бодисын сав баглаа боодлыг ил задгай хаях	Болзошгүй осол, эрсдэлээс урьдчилан сэргийлэх төлөвлөгөөтэй байх	Барилгын чулууны орд	“Пауэр Бласт” ХХК	“Пауэр Бласт” ХХК-тай байгуулсан гэрээний үнийн дүнд багтана.	2023 онд	-Галын аюулгүй байдлын тухай хууль -Химийн хорт болон аюултай бодисын тухай хууль -Тэсэрч дэлбэрэх бодис, тэсэлгээний хэрэгслийн эргэлтэд хяналт тавих тухай хууль
2		Тэсрэх бодисыг хадгалах, ачих, тээвэрлэх, хүлээн авах, зарцуулах явцад сав баглаа боодол задарч асгарахаас сэргийлэх, хяналт тавьж байх	Барилгын чулууны орд				
3		Тэсрэх бодис асгарсан үед ашиглах багаж хэрэгсэл, цэвэрлэгээний материалыг бэлтгэж бэлэн болгох	Барилгын чулууны орд				
4		Ашиглагдсан тэсрэх бодисын сав баглаа боодлыг орон нутгаас зааж өгсөн талбайд булшлах, устгах арга хэмжээ авах	Барилгын чулууны орд				

5.7. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

Энэ төлөвлөгөөнд батлагдсан аргачлалын дагуу хийсэн байгалийн аюул, гамшгийн үнэлгээгээр тогтоогдсон учирч болзошгүй байгалийн гамшиг, түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр авч хэрэгжүүлэх арга хэмжээ, шаардагдах зардлыг тусгалаа.

Хүснэгт №7. Осол, эрсдэлийн менежментийн төлөвлөгөө

№	Болзошгүй аюул осол, сөрөг нөлөөлөл	Урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээ	Арга хэмжээний цар, хүрээ	Тоо хэмжээ	Нэгжийн зардал, төгрөг	Зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт ба аргачлал
1	Болзошгүй аюул, осол, саатал, техник технологийн шугам сүлжээний гэмтэл, галын гэнэтийн аюул үүсэх	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмжийн аюулгүй байдлыг тогтмол шалгах, хянах	Тээврийн хэрэгсэл, тоног төхөөрөмж		-	-	Үйл ажиллагааны туршид	-Гамшгаас хамгаалах тухай хууль, 2003 (сүүлийн нэмэлт өөрчлөлт 2012 оны 5 сарын 17) -MNS6010-2009 Гамшгийн холбогдолтой нэр томьёо, тодорхойлолт, ерөнхий анги
2		Галын болон болзошгүй аюул, ослоос урьдчилан сэргийлэх арга хэмжээний талаар сургалт зохион байгуулах	Уурхайн ажилчид		300,000.0		Жилд 1 удаа	
3		Галын дохиоллын систем суурилуулах, гал унтраах хэрэгслийг зохих газруудад байрлуулах	Уурхайд			-	Жилд 1 удаа	
Нийт зардал						300,000		

ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Цээцээ Импекс” ХХК нь Хан-Уул дүүргийн 16-р хорооны “Хан Эко Тээвэр” ОНӨААТҮГ-тэй хог хаягдлын гэрээ байгуулан ажилладаг бөгөөд гэрээт байгууллага хог хаягдлын менежментийг хэрэгжүүлж, компаний зүгээс хяналт тавьж ажилладаг.

Хүснэгт №8. Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө



Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших “Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд” -ын
2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөө

№	Хог хаягдлын ангилал	Сөрөг нөлөөллийг арилгах, бууруулах арга хэмжээ	Сөрөг нөлөөллийн хамрах хүрээ	Хэмжих нэгж	Нэгжийн зардал, төгрөг	Хэрэгжүүлэх хугацаа ба давтамж	Баримтлах стандарт ба аргачлал
1	Хог хаягдал /хатуу/	-Ахуйн хог хаягдлаа орон нутагтай гэрээ байгуулан тээвэрлүүлэх -Хатуу хог хаягдлын цэгийн гадна талд болон бусад орчинд хог алдагдахаас сэргийлэн хашааг тохижуулах	Уурхайн талбайн	-	150.000	Жилд 1 удаа	- Хог хаягдлын тухай хууль
Нийт					150.000.0		

5.9. ОРЧНЫ ХЯНАЛТ ШИНЖИЛГЭЭНИЙ ХӨТӨЛБӨР

Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр (ОХШХ) нь “Цээцээ импекс” ХХК-иас явуулж байгаа үйл ажиллагаа, хэрэгжүүлж байгаа төсөл нь байгаль орчин, хүний амьдрах орчинд хэрхэн нөлөөлж байгаа, үзүүлж буй нөлөөлөл нь зөвшөөрөгдөх хязгаарт байгаа эсэхийг хянах үзүүлэлтүүдийг тодорхойлж, хэмжих, шинжлэх арга, стандарт, хяналт хийх байршил, давтамж зэргийг бүхэлд нь тусгасан нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний нэг чухал баримт бичиг юм.

Уг ордын үйл ажиллагааны явцад БОННУ-ий тайлан, БОХТ-д тусгасан болзошгүй болон гол сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээ, тухайн орчинд төслийн үйл ажиллагаанаас шалтгаалан гарсан өөрчлөлтүүдийг тодорхойлох, хянах зорилгоор тогтмол дээжлэлт, сорьц авч байх үзүүлэлтүүд, түүний тодорхойлолт, хуваарь баримтлах стандарт, аргачлал, зардлыг тодорхойлон орчны хяналт шинжилгээний хөтөлбөрт тусгав.

Байгаль орчныг хамгаалах тухай, Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай Монгол Улсын хуулиудын дагуу “Цээцээ импекс” ХХК нь батлагдсан арга, аргачлалаар, итгэмжлэгдсэн тоног төхөөрөмжөөр байгаль орчны хяналт шинжилгээний ажлыг явуулах шаардлагатай. Тухайн жилд хийсэн хяналт шинжилгээний үр дүнгүүдийг жил бүрийн 12 дугаар сарын 1-ний дотор холбогдох төрийн захиргааны төв байгууллага (Байгаль орчин, ногоон хөгжил, аялал жуулчлалын яам)-д хүргүүлэн хянуулж, дараа оныхоо төлөвлөгөөг батлуулж ажиллах ёстой.

Хүснэгт №9. Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр

№	Хяналт шинжилгээ хийх үзүүлэлтүүд	Хяналтын цэгийн байршил	Хугацаа ба давтамж	Нийт зардал, төг	Тайлбар	Баримтлах стандарт, арга аргачлал
Агаар						
1	Агаарын тоосны (TSP, PM ₁₀ , PM _{2.5}) шинжилгээ мэргэжлийн байгууллагаар хийлгэх	Бутлуур, дотоод тээвэрлэлтийн замаас, ил уурхай	Жилд 1 удаа	300,000.0	Цаг уур орчны шинжилгээний газрын байгаль орчны хэмжилзүйн төв лаборатори	- Агаарын бохирдлын төлбөрийн тухай хууль -MNS 4585:2007 Агаарын чанар. Техникийн ерөнхий шаардлага - MNS 0017-2-3-16:1988. Агаар мандал. Хот суурингийн агаарын бохирдлын шинжилгээ - MNS 5061:2001. Нүүрсхүчлийн хий. CO ₂ тодорхойлох эзлэхүүний арга
Хөрс						
2	Хөрсний химийн үзүүлэлт (рН, EC _{2.5} dS/m, P ₂ O ₅ , K ₂ O, CaCO ₃)	Уурхайн карьерийн гадна талаас зонхилох салхины чиглэлийн дагуу	Жилд 1 удаа	45,000.0	ШУА, Газарзүй-Геозкологийн хүрээлэн, хөрсний шинжилгээний лаборатори	-MNS 3473:1983 Газар. Газрын эдэлбэр. Газар ашиглалт. -MNS 3985: 87. Хөрсний ариун цэврийн байдлын үзүүлэлтийн нэр, төрөл -MNS 3310:91. Хөрсний агрохимийн үзүүлэлтийг тодорхойлох
3	Хөрсний хүнд металлын бохирдол тодорхойлох (Cr, Cd, Pb, Ni, Co)	Шатах тослох материалын агуулах, бохирдсон байж болох цэгүүдэс дээж авах	Жилд 2 удаа	45,000.0		
Ус						
4	Усны химийн шинжилгээ (рН, EC, TDS) нийт шүтлэг, хатуулгын хэмжээ (CaCO ₃)	Ахуйн хэрэглээний уснаас	Жилд 2 удаа	46,000.0	ШУА, Газарзүй-Геозкологийн хүрээлэн, усны шинжилгээний лаборатори	- MNS 0900:1992. Ундны ус, ундны усны хяналт шинжилгээ - MNS 3935:1986. Ундны ус хяналт шинжилгээнд тавих ерөнхий шаардлага - MNS 3934:1986 Ундны болон үйлдвэрийн ус-химийн шинжилгээ хийх-дээж авах, хадгалах, зөөвөрлөх - MNS4432:1997 Ундны ус. Өнгийг тодорхойлох арга.
Нийт зардал				500,000.0		

5.10. БОМТ-Г ХЭРЭГЖҮҮЛЭХ УДИРДЛАГА, ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨ

“Цээцээ импекс” ХХК-ийн Байгаль орчны мэргэжилтэн нь байгаль орчны асуудлыг хариуцан ажиллаж, БОХТ, БОХШХ-ийг хэрэгжүүлж, хэрэгжилтийн үр дүн, тайланг компаний удирдлага, байгаль орчныг хариуцсан бүх шатны төр, захиргааны байгууллагын өмнө хариуцан ажиллах үүрэг хүлээнэ.

Хүснэгт №10. Удирдлага зохион байгуулалтын төлөвлөгөө

№	Төлөвлөсөн арга хэмжээ	Арга хэмжээний цар хүрээ	Урьдчилсан төсөв мян.төг	Хэрэгжүүлэх хуваарь	Хариуцсан албан тушаалтан	Баримтлах стандарт ба аргачлал Тайлбар
1	Байгаль орчны удирдлага зохион байгуулалтын арга хэлбэрийг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэх чиглэлээр үүрэг хариуцлагын дотоод журам тогтоож мөрдөх	Уурхайн ажилчид	Дотоод төлөвлөлтөөр	Байнга	“Цээцээ импекс” ХХК-ийн захирал	-MNS 5002 2000: Хөдөлмөрийн аюулгүй ажиллагаа, эрүүл ахуй
2	Ажилчдад хөдөлмөр хамгаалал аюулгүй ажиллагааны талаар сургалтыг мэргэжлийн байгууллага хүмүүстэй хамтран зохион байгуулах	Уурхайн ажилчид	Дотоод төлөвлөлтөөр	Жил бүр	“Цээцээ импекс” ХХК-ийн захирал	-Шуугианы норм, аюулгүй ажиллагаа-ны ерөнхий шаардлага
3	Байгаль орчныг хамгаалах талаар сургалтыг жилд нэг удаа зохион байгуулах, холбогдох байгаль хамгаалагч нартай харилцан холбоотой ажиллах	Уурхайн ажилчид	-	Жил бүр	“Цээцээ импекс” ХХК-ийн захирал	-MNS 12.4. 005 - 1985 Хөдөлмөр хамгаалал. –жил бүр Шуугианаас -хамгаалах хэрэгсэл ба аргууд
4	Ажилчидыг хувцас хэрэгслээр хангах	Уурхайн ажилчид	ХАБЭА-ын зардалд тусгагдана		“Цээцээ импекс” ХХК-ийн захирал	

5.11. ТУХАЙН ЖИЛИЙН БАЙГАЛЬ ОРЧНЫГ ХАМГААЛАХ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТИЙГ НӨЛӨӨЛЛИЙН БҮСИЙН ОРШИН СУУГЧДАД ТАЙЛАГНАХ ТӨЛӨВЛӨГӨӨ

Байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулах шатанд олон нийтийн оролцоо, тэр дундаа төслийн сөрөг нөлөөлөлд өртөж болзошгүй нутгийн иргэд, орон нутгийн байгууллагын оролцоог нэмэгдүүлэх, хууль тогтоомжид заасан хүрээнд тэдэнд аль болох ойлгомжтой бөгөөд үнэн зөв, бодит мэдээллийг өгч, зөрчигдөж болзошгүй эрхээ хамгаалах санал бодлыг судлан тусгах нь энэ шатны ажлын гол зорилт юм.

Хүснэгт №11. Тухайн жилийн байгаль орчныг хамгаалах төлөвлөгөөний биелэлтийг нөлөөллийн бүсийн оршин суугчдад тайлагнах төлөвлөгөө

№	БОХТ-ний биелэлтийг тайлагнахад оролцогч талууд	Тайлагнах хэлбэр	Мэдээллийн агуулга	Зохион байгуулах хугацааны тов	Тайлагнах зардал, төг	Хариуцан зохион байгуулах албан тушаалтан/ ажилтан	Зохион байгуулах газар
1	Улаанбаатар хот, Хан-Уул дүүргийн ИНХ	Уулзалт, санал асуулга	БОМТ болон хяналт, шинжилгээний гүйцэтгэлийг тайлагнах	11-р сар	Дотоод төлөвлөлтөөр	“Цээцээ импекс” ХХК	Улаанбаатар хотын Хан-Уул дүүрэг
2	БОАЖЯ-ны ХБОБНУГ-т	Тайлангийн эх хувь, албан бичиг	Тайланг хүлээн авсан актыг хүргүүлэх	12-р сар	Дотоод төлөвлөлтөөр	“Цээцээ импекс” ХХК	-
3	Байгаль орчны хяналтын улсын байцаагч, орон нутгийн байцаагч, Бүх шатны засаг дарга, байгаль орчны төрийн бус байгууллага	Танилцуулж тайлагнах	Тухайн жилийн БОМТ-ий хэрэгжилтийн талаар	Хагас жил тутам буюу 6, 11 сард	Дотоод төлөвлөлтөөр	“Цээцээ импекс” ХХК	Засаг даргын тамгын газар

5.12. БАЙГАЛЬ ОРЧНЫ МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ НИЙТ ЗАРДАЛ

Хүснэгт №12. Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний нийт зардал

№	Хэрэгжүүлэх арга хэмжээ	Нийт зардал, төгрөг
1	Сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээний төлөвлөгөө	500,000.0
2	Дүйцүүлэн хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө	5,900,000.0
6	Осол эрсдлийн менежментийн төлөвлөгөө	300,000.0
7	Хог хаягдлын менежментийн төлөвлөгөө	150,000.0
10	Орчны хяналт шинжилгээний хөтөлбөр	500,000.0
Нийт		7,350,000

“Цээцээ Импекс” ХХК-ний Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордын байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд 2023 онд нийт 7.3 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөв.

ДҮГНЭЛТ

“Цээцээ импекс” ХХК-ний байгаль орчны менежментийн төлөвлөгөөг боловсруулахад дараахь дүгнэлтэнд хүрлээ.

Байгаль орчныг хамгаалах төлөвлөгөө, Байгаль орчны хяналт шинжилгээний хөтөлбөрийг мөрдлөг болгон цаг хугацаанд нь хэрэгжүүлэх шаардлагатай.

Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны ордын үйл ажиллагааны явцад хөрс хамгийн ихээр элэгдэл эвдрэлд орох учир нөхөн сэргээлт хийх зайлшгүй шаардлагатай.

2023 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөнд нийт 7.3 сая төгрөг гарахаар тооцоолсноос 50% –ийг нь Байгаль орчин, нөхөн сэргээх санд байршуулах зайлшгүй шаардлагатай.

Энэхүү байгаль орчны менежментийн төлөвлөгөөний арга хэмжээнүүдийг цаг тухайд бүрт мөрдлөг болгож, хэрэгжүүлсэн нөхцөлд энэхүү төслийг цаашид үргэлжлүүлэн хэрэгжүүлэх бүрэн боломжтойгоос гадна шинээр ажлын байр нэмэгдэх, орон нутагт их хэмжээний хөрөнгө оруулалт хийгдэх төлөвлөгөөтэй байна.

АШИГЛАСАН ХЭВЛЭЛ

1. Монгол Улсын Байгаль орчныг хамгаалах тухай хууль, 1995 он
2. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний тухай хууль, 1998 он
3. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээний аргачилсан заавар УБ 2010.
4. Байгаль орчин, аялал жуулчлалын салбарын стандартуудын эмхтгэл УБ 2010.
5. Журам шинэчлэн батлах тухай Байгаль орчин аялал жуулчлалын Сайдын А-36 тоот тушаал, 2011 оны 2 дугаар сарын 16, 1-р хавсралт
6. “БОМТ боловсруулах, хянан батлах, тайлагнах журам” Сайдын тоот тушаал, 2019 он
7. Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших “Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд” –ыг ил аргаар ашиглах төслийн Байгаль орчны нөлөөллийн нарийвчилсан үнэлгээний тайлан, 2019 он
8. Улаанбаатар хотын Хан-Уул дүүргийн нутагт орших “Морин уулын өмнөд хэсгийн барилгын чулууны орд” -ыг ашиглах ТЭЗҮ 2019 он
9. Байгаль орчинд нөлөөлөх байдлын үнэлгээ, үнэлгээ аудитын журам, аргачлал 2014 он
10. <http://www.legalinfo.mn>

Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны А/134 дүгээр тушаалаар зөвшөөрснөөр, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 09 сарын 19-ны өдрийн А/527 дугаар тушаалаар батлав.

УУЛ УУРХАЙН ҮЙЛ АЖИЛЛГААНЫ УЛМААС ЭВДЭРСЭН ГАЗРЫН НӨХӨН СЭРГЭЭЛТИЙН 2023 ОНЫ ЖИЛИЙН МЭДЭЭ

1. Аж ахуйн нэгж, байгууллагын хаягийн хэсэг

Регистрийн дугаар	2	8	0	4	8	1	6
Аж ахуйн нэгж байгууллагын нэр	"Цээцээ Импекс" ХХК						
Байршил	Нэр					Код	
Аймаг, нийслэл	Улаанбаатар						
Сум, дүүрэг	Хан-Уул						

2. Ерөнхий мэдээлэл

Тусгай зөвшөөрлийн дугаар	М	V	0	0	7	1	3	4
Тусгай зөвшөөрлийн талбай, га	54.26							
Ашигласан эхэлсэн он, сар, өдөр	2	0	1	3				
Ашигт малтмалын төрөл	Барилгын чулууны орд							
Ашиглалтын төрөл	Барилгын чулууны орд							

3. Уул уурхайн ашиглалт

Үзүүлэлт	МД	Хэмжих нэгж	Нийт	Тайланд онд /ашиглалт хийсэн/
А	Б	В	1	2
Олборлолтод өртсөн нийт талбай	1	-	х	х
Ашигласан талбай	2	га		
	3	мян.м ³		
Хүдэр олборлолт	4	га		
	5	мян.м ³		500
Бүтээгдэхүүн гаргалт	6	га		
	7	мян.м ³		543
Хөрсний эзлэхүүн	8	га		
	9	мян.м ³		57.66
Хүдрийн хэмжээ	10	га		
	11	мян.м ³		517,45
Хөрс хуулалт	12	га		
		мян.м ³		62.24

4. Уул уурхайн нөхөн сэргээлт

Үзүүлэлт	МД	Хэмжих нэгж	Нийт	Техникийн	Биологийн
А	Б	В	1	2	3
Байгаль орчны нөлөөлөх байдлын үнэлгээнд заасан нөхөн сэргээлт хийх нийт талбайн хэмжээ	10	га	-	-	-
	11	мян.м ³	-	-	-
Тайлант онд нөхөн сэргээлт хийхээр төлөвлөсөн талбай	12	га	Мод тарих ажил тусгагдсан		
	13	мян.м ³	-	-	-
	14	га	Мод тарих ажил тусгагдсан		

Үндэсний статистикийн хорооны даргын 2019 оны А/134 дүгээр тушаалаар зөвшөөрснөөр, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2019 оны 09 сарын 19-ны өдрийн А/527 дугаар тушаалаар батлав.

Нөхөн сэргээлт нийт хийсэн талбай	15	мян.м ³	-	-	-
Тайланд онд нөхөн сэргээлт хийсэн талбай	16	га	Мод тарих ажил тусгагдсан		
	17	мян.м ³	-	-	-
Нөхөн сэргээлт хийхэд зарцуулсан нийт зардал	18	мян.төг	-	-	-
Дүйцүүлэн хамгаалалтын зардал	19	мян.төг	-	-	5,9
Байршуулсан нөхөн сэргээлтийн баталгааны нийт мөнгөн хөрөнгө	20	мян.төг	-	-	-
Тайланд онд байршуулсан нөхөн сэргээлтийн баталгааны мөнгөн хөрөнгө	21	мян.төг	-	-	6,6
Байгаль хамгаалахад зарцуулсан нийт зардал	22	мян.төг	-	-	8,8
Тайланд онд байгаль хамгаалахад зарцуулсан зардал	23	мян.төг	-	-	7,3

ТАМГА

Захирал /Эзэн...../

/

Нягтлан бодогч...../

/